



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 123

Өлгий

Аймгийн нутаг дэвсгэрээс 2023 онд ойгоос бэлтгэх  
модны дээд хязгаар тогтоох тухай

Монгол улсын Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 32 дугаар зүйлийн 32.2 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны А/327 дугаар тушаалыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит X хуралдаанаас ТОГТООХ нь:

1. 2023 онд аймгийн нутаг дэвсгэрт ойн сангаас бэлтгэх модны дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Ойгоос бэлтгэх модыг батлагдсан дээд хязгаарт багтаан ой бүхий сумдаас арчилгаа, цэвэрлэгээний журмаар холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Марат), Сум дундын ойн анги (Х.Есенбол) болон холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Ойгоос хэрэглээний мод бэлтгэх ажлыг холбогдох заавар, журмын дагуу гүйцэтгүүлж, бэлтгэсэн модны 100 шоо метр тутамд өөрийн хөрөнгөөр 2 га талбайд ой тарьж ургуулах, 3 га талбайд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг холбогдох нөхөрлөл аж ахуйн нэгж байгууллагаар хийлгэх арга хэмжээ зохион байгуулахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Марат)-т даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Бауыржан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.БЕЙБИТХАН

Аймгийн ИТХ-ын 2022 оны 10  
дугаар сарын 27-ний өдрийн  
ээлжит Х хуралдааны 123  
дугаар тогтоолын хавсралт

Аймгийн нутаг дэвсгэрийн ойн сангаас 2023 онд бэлтгэх модны дээд хязгаар

Огтлолтын төрөл	Зориулалт	Модны төрөл	Хэмжих нэгж	Сумдын нэр							
				Алтанцөгц	Баяннуур	Бугат	Булган	Ногооннуур	Улаанхус	Цэнгэл	Бүгд
Арчилгааны огтлолт	Хэрэглээ	Шинэс	м <sup>3</sup>				50			50	100
		Дүн	м <sup>3</sup>				50			50	100
	Түлээ	Шинэс	м <sup>3</sup>				20			50	70
		Дүн	м <sup>3</sup>				20			50	70
Бүгд			м <sup>3</sup>				70			100	170
			га				8.2			11.8	20
Цэвэрлэгээний огтлолт	Хэрэглээ	Шинэс	М <sup>3</sup>		5		150		20	175	350
		Улиас	М <sup>3</sup>	50	42	25	15	48			180
		Бургас	М <sup>3</sup>	18	10	5		17			50
		Хус	М <sup>3</sup>	25	10	20		25			80
	Дүн		М <sup>3</sup>	93	67	50	165	90	20	175	660
	Түлээ	Шинэс	М <sup>3</sup>		5		85		10	100	200
		Улиас	М <sup>3</sup>	75	50	40	20	65			250
		Бургас	М <sup>3</sup>	60	40	30	5	65			200
		Хус	М <sup>3</sup>	25	15	15	5	20			80
	Дүн		М <sup>3</sup>	160	110	85	115	150	10	100	730
Бүгд			М <sup>3</sup>	253	177	135	280	240	30	275	1390
			га	16.9	11.8	9	18.7	16.1	2	18.4	93
Цэвэрлэгээний ажил	Хэрэглээ	Шинэс	М <sup>3</sup>		15		595		20	620	1250
		Улиас	М <sup>3</sup>	55	45	35	10	55			200
		Бургас	М <sup>3</sup>	28	20	15	5	32			100
		Хус	М <sup>3</sup>	30	15	20	5	30			100
	Дүн		М <sup>3</sup>	113	95	70	615	117	20	620	1650
	Түлээ	Шинэс	М <sup>3</sup>		100		1490		80	1880	3550
		Улиас	М <sup>3</sup>	196	177	171	50	206			800
		Бургас	М <sup>3</sup>	407	396	350	80	410	7		1650
		Хус	М <sup>3</sup>	35	20	25	35	5			120
	Дүн		М <sup>3</sup>	638	693	546	1655	621	87	1880	6120
Бүгд			М <sup>3</sup>	751	788	616	2270	738	107	2500	7770

	га	50.1	52.5	41.1	151.3	49.2	7.1	166.7	518
Нийт дүн	М <sup>3</sup>	1004	965	751	2620	978	137	2875	9330
	га	67	64.4	50.1	178.3	65.3	9.1	196.8	631

